

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/123/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<b>АОУС</b>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<b>УСНББОУС</b>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<b>ТТЗ</b>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<b>ТШЗ</b>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<b>БСШУСЯ</b>	<i>Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам</i>
<b>ТӨХК</b>	<i>Төрийн өмчит хувьцаат компани</i>
<b>ОНХС</b>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<b>БҮТЭЗ</b>	<i>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл</i>
<b>БТСГ</b>	<i>Биеийн тамир, спортын газар</i>
<b>ХХОАТ</b>	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>
<b>УАШТ</b>	<i>Улсын аварга шалгаруулах тэмцээн</i>

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Залруулсан алдаа .....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж .....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19

## 1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ч.ТҮМЭНДЭМБЭРЭЛ ТАНАА

2021-02-02, № 2/20  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир Спортын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурьдсан алдаа зөрчлийг эс тооцвол Биеийн тамир Спортын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдээгүй тул хязгаарлалттай санал, дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биеийн тамир Спортын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын

021020149

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Аудитын гол асуудал**

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг мэдээллээгүй, санхүүгийн тайланд өглөг, авлага, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн зэрэг зөрчлүүд "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулга ба тодруулга", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>33,663,134.19</u>	<u>50,696,471.26</u>
33	<b>АВЛАГА</b>	1,001,384.19	14,216,121.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,001,384.19	1,096,121.26
335	<b>Бусад авлага</b>	-	13,120,000
3351	Байгууллагаас авах авлага		13,120,000
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	32,661,750	36,480,350
351	<b>Түүхий эд материал</b>	19,800,750	19,800,750
35110	Тусгай зориулалттай материал	19,800,750	19,800,750
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5,261,000	6,505,000
354	<b>Хангамжийн материал</b>	7,600,000	10,174,600
35410	Бичиг хэргийн материал	813,000	873,000
35420	Аж ахуйн материал	300,000	300,000
35430	Сэлбэг хэрэгсэл	40,500	40,500
35450	Барилгын засварын материал	6,446,500	7,472,000
35470	Бусад хангамжийн материал	-	1,489,100
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>3,112,842,214.74</u>	<u>3,061,968,225.91</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,112,842,214.74	3,061,968,225.91
392	<b>Биет хөрөнгө</b>	2,934,859,714.82	2,884,024,225.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,589,632,943.57	3,589,632,943.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(770,676,256.01)	(933,355,689.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		71,789,584.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(5,106,666.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,957,837.33	231,957,837.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(106,945,405.11)	(129,120,168.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,288,737.29	59,288,737.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,262,568.67)	(44,043,674.38)
39209	Зам, гүүрийн байгууламж	45,801,530.74	45,801,530.74
39210	Хуримтлагдсан элэгдэл	(10,937,104.32)	(12,820,208.64)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000	10,000,000
393	<b>Биет бус хөрөнгө</b>	177,982,499.92	177,944,000
39301	Программ хангамж	880,000.0	880,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(841,500.08)	(880,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	177,944,000.0	177,944,000.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>3,146,505,348.93</u>	<u>3,112,664,697.17</u>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<u>65,860,320.00</u>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	65,860,320.0
413	<b>Өглөг</b>	-	65,860,320.0
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		13,120,000.0
4136	<b>Бусад өглөг</b>	-	52,740,320.0
41361	Байгууллагад төлөх өглөг		52,740,320.0

5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,146,505,348.93</b>	<b>3,046,804,377.17</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,146,505,348.93	3,046,804,377.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	680,905,756.0	680,905,756.0
51101	Өмч: - төрийн	503,461,756.0	503,461,756.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	177,444,000.0	177,444,000.0
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(82,856,521.62)	(182,557,493.38)
51210	Өмнөх үеийн үр дүн	(82,856,521.62)	(101,141,821.62)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(81,415,671.76)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,548,456,114.55	2,548,456,114.55
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> VI=IV+V	<b>3,146,505,348.93</b>	<b>3,112,664,697.17</b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	610,648,400	686,220,284
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	134,151,900	188,624,584
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,200,000	169,789,584
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,200,000	169,789,584
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,200,000	500,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		22,500,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		146,789,584
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	130,951,900	18,835,000
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	130,951,900	18,835,000
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	476,496,500	497,595,700
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	476,496,500	497,595,700
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	476,069,400	476,496,500
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	789,841,229.68	780,756,725.49
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	789,841,229.68	780,756,725.49
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	778,976,885.68	745,365,186.03
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	190,811,712	203,514,943.20
210101	Үндсэн цалин	190,811,712	203,514,943.20
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,812,199	24,860,515.50
210201	Тэтгэврийн даатгал	16,202,885	17,096,844
210202	Тэтгэмжийн даатгал	1,902,330	2,019,390
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,521,862	1,609,116
210204	Ажилгүйдлийн даатгал	380,466	375,926
210205	Эрүүл мэндийн даатгал	3,804,656	3,759,240
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	208,555,118	249,738,745.50
210301	Гэрэл, цахилгаан	4,310,828	3,259,915.50
210302	Түлш, халаалт	194,395,650	234,661,350
210303	Цэвэр, бохир ус	9,848,640	11,817,480
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,200,720	4,767,840

210401	Бичиг хэрэг	689,800	517,000
210402	Тээвэр, шатахуун	2,653,000	3,000,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,440	108,840
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,000	490,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	576,480	652,000
2105	<b>Нормативт зардал</b>	215,300	48,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	215,300	48,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	719,900	231,900
210702	Дотоод албан томилолт	719,900	231,900
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,345,280	4,876,469
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,095,280	3,969,760
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	242,000
210803	Даатгалын үйлчилгээ	-	39,120
210804	Тээврийн хэрэгслийн татвар		35,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	7,800
210807	Газрын төлбөр		300,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		282,789
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	346,316,656.87	257,326,772.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,041,675	59,663,200
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,274,981.87	197,663,572.83
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,864,344	35,391,539.46
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	732,422	13,120,769.73
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	732,422	13,120,769.73
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,399,500	9,150,000
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,599,500	8,750,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000	400,000
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	732,422.00	13,120,769.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	732,422.00	13,120,769.73
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<u>(179,192,829.68)</u>	<u>(94,536,441.49)</u>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<u>(180,197,569.68)</u>	<u>(94,536,441.49)</u>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>610,648,400</u>	<u>539,430,700</u>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	134,151,900	41,835,000
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,200,000	23,000,000
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,200,000	23,000,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,200,000	500,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		22,500,000
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	130,951,900	18,835,000
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	130,951,900	18,835,000

13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	476,496,500	497,595,700
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	476,496,500	497,595,700
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	476,496,500	497,595,700
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>610,648,400</b>	<b>539,430,700</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	610,648,400	539,430,700
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	600,516,478	517,159,930.27
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	191,789,095	201,269,125.43
210101	Үндсэн цалин	172,302,295	165,706,428.43
210102	Нэмэгдэл	19,486,800	35,562,697
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,546,200	28,201,070.34
210201	Тэтгэврийн даатгал	16,691,400	19,575,670.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,963,700	2,156,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,571,000	1,725,000
210204	Ажилгүйдлийн даатгал	392,700	431,500
210205	Эрүүл мэндийн даатгал	3,927,400	4,312,600
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	208,555,118	215,283,725.50
210301	Гэрэл, цахилгаан	4,310,828	3,259,915.50
210302	Түлш, халаалт	194,395,650	200,206,330
210303	Цэвэр, бохир ус	9,848,640	11,817,480
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,450,710	4,870,840
210401	Бичиг хэрэг	543,000	517,000
210402	Тээвэр, шатахуун	2,653,000	3,000,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,440	163,840
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,000	490,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	973,270	700,000
2105	<b>Нормативт зардал</b>	215,300	200,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	215,300	200,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	719,900	231,900
210702	Дотоод албан томилолт	719,900	231,900
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,817,780	6,556,469
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,567,780	5,649,760
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	242,000
210803	Даатгалын үйлчилгээ		39,120
210804	Тээврийн хэрэгслийн татвар		35,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	7,800
210807	Газрын төлбөр		300,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		282,789
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	165,422,375	60,546,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	165,422,375	60,546,800
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,131,922.00	22,270,769.73
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,399,500.00	9,150,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,599,500.00	8,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	400,000.00

2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	732,422.00	13,120,769.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	732,422.00	13,120,769.73
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (3)=(1)-(2)	=	=

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	680,905,756	2,548,456,114.55	96,608,626.06	3,325,970,496.61
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	680,905,756	2,548,456,114.55	(82,856,521.62)	3,146,505,348.93
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	680,905,756	2,548,456,114.55	(82,856,521.62)	3,146,505,348.93
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	680,905,756	2,548,456,114.55	(82,856,521.62)	3,146,505,348.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(18,285,300.00)	(18,285,300.00)
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	680,905,756	2,548,456,114.55	(101,141,821.62)	3,128,220,048.93
D08	Тайлант үеийн үр дүн			(81,415,671.76)	(81,415,671.76)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	680,905,756	2,548,456,114.55	(182,557,493.38)	3,046,804,377.17

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	486,496,500	478,980,878	505,095,700	498,095,130.27
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	486,496,500	478,980,878	505,095,700	498,095,130.27
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	477,097,000	469,581,378	496,345,700	488,945,130.27
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	174,681,200	191,789,095	207,057,400	201,269,125.43
210101	Үндсэн цалин	155,194,400	172,302,295	171,623,600	165,706,428.43
210102	Нэмэгдэл	19,486,800	19,486,800	35,433,800	35,562,697.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,835,100	24,546,200	27,953,100	28,201,070.34
210201	Тэтгэврийн даатгал	14,847,900	16,691,400	19,670,800	19,575,670.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,746,800	1,963,700	2,070,600	2,156,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,397,400	1,571,000	1,656,500	1,725,000
210204	Ажилгүйдлийн даатгал	349,400	392,700	414,100	431,500
210205	Эрүүл мэндийн даатгал	3,493,600	3,927,400	4,141,100	4,312,600
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	233,050,700	208,555,118	226,410,000	215,283,725.50
210301	Гэрэл, цахилгаан	3,184,800	4,310,828	4,002,000	3,259,915.50

210302	Түлш, халаалт	202,865,900	194,395,650	210,590,500	200,206,330
210303	Цэвэр, бохир ус	27,000,000	9,848,640	11,817,500	11,817,480
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,030,000	4,450,710	4,870,800	4,870,840
210401	Бичиг хэрэг	690,000	543,000	517,000	517,000
210402	Тээвэр, шатахуун	3,000,000	2,653,000	3,000,000	3,000,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000	46,440	163,800	163,840
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000	235,000	490,000	490,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000	973,270	700,000	700,000
2105	<b>Нормативт зардал</b>	300,000	215,300	200,000	200,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000	215,300	200,000	200,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,700,000	719,900	231,900	231,900
210702	Дотоод албан томилолт	1,700,000	719,900	231,900	231,900
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,000,000	4,817,780	6,556,300	6,556,469
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,589,000	4,567,780	5,649,700	5,649,760
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	250,000	242,000	242,000
210803	Даатгалын үйлчилгээ	74,000		39,100	39,120
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,000		35,000	35,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	14,000		7,800	7,800
210807	Газрын төлбөр	38,000		282,700	300,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			300,000	282,789
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,500,000	34,487,275	23,066,200	32,332,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,500,000	34,487,275	23,066,200	32,332,000
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,399,500	9,399,500	8,750,000	9,150,000
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,399,500	9,399,500	8,750,000	9,150,000
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,599,500	8,599,500	8,750,000	8,750,000
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	486,496,500	478,980,878	505,095,700	498,095,130.27
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	476,496,500	475,780,878	497,595,700	497,595,130.27
131001	Улсын төсвөөс санхүүжих	476,496,500	475,780,878	497,595,700	497,595,130.27
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,000,000	3,200,000	7,500,000	500,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000	3,200,000	7,500,000	500,000
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25	25	25	25
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	14	14
620003	Үйлчлэх ажилтан	10	10	10	10
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	25	25	25	25

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	3	3	3	3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22	22	22	22

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	130,935,100	41,335,000
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	130,935,100	41,335,000
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	130,935,100	28,214,800
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	130,935,100	28,214,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,935,100	28,214,800
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	13,120,200
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	13,120,200
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		13,120,200
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	130,951,900	41,335,000
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	130,951,900	41,335,000
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,835,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	130,951,900	22,500,000

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. Ерөнхий зүйл

Биеийн тамир, спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Түмэндэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын зарцуулалт, ур чадварын болон улирлын мөнгөн урамшуулал, санхүүгийн программ хангамж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 29-нөөс 2021 оны 02 дугаар сарын 02-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Биеийн тамир, спортын газар нь “Иргэдэд нийтийн биеийн тамирыг таниулан сурталчлах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, 2020 онд аймагтаа Чөлөөт бөх, ширээний теннисний Улсын аварга шалгаруулах тэмцээн анх удаа зохион байгуулах, аймгийн шигшээ багийг бүрдүүлэх тэдний залгаж халааг бэлтгэн тив, дэлхийн спортод шилдэг тамирчид бэлтгэх, өмнөх амжилтуудаа бататгах, албан байгууллага хамт олны дунд нийтийн биеийн

тамирын арга хэмжээг зохион байгуулах, Засаг даргын дэргэдэх үндэсний шигшээ багийг топ төрлүүдээр бүрдүүлэх” гэсэн зорилго, зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх зүйн үндсийг тодорхойлох,
- Биеийн тамир, спортыг хөгжүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Биеийн тамир, спортын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 610648.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6106.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 686220.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6862.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### **3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Биеийн тамир, спортын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38406.6 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр, төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	1,001.4	14,216.1	13,214.7
Бараа материал	32,661.7	36,480.4	3,818.7
Үндсэн хөрөнгө	3,112,842.2	3,061,968.2	(50,874.0)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,146,505.3</b>	<b>3,112,664.7</b>	<b>(33,840.6)</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		<b>65,860.3</b>	<b>65,860.3</b>
Цэвэр хөрөнгө, өмч	3,146,505.3	3,046,804.4	(99,700.9)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,146,505.3</b>	<b>3,112,664.7</b>	<b>(33,840.6)</b>

Авлага дансны үлдэгдэл 14216.1 мянган төгрөг болж 13214.7 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь нэмэлт санхүүжилтийн дансаар Фитнесийн тоног төхөөрөмж бэлтгэх зардалд БТСГ-аас олгосон 13120.0 мянган төгрөгийг оны эцэст шилжүүлсэнтэй холбоотой, авлага бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36480.4 мянган төгрөг болж 3818.7 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой БҮТЭЗ-ийг худалдан авснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онд худалдаж авч урсгал засварын үйл ажиллагаанд зарцуулсан 8558.7 мянган төгрөгийн бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4187294.6 мянган төгрөг болж 146789.6 мянган төгрөгөөр өссөн нь харьяа дээд шатны байгууллага болон аймгийн ЗДТГ-аас тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУСЯамны хөрөнгө оруулалтаар 33600.0 мянган төгрөгийн Пургон автомашин, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн БТСГаараас 75000.0 мянган төгрөгийн байт харвааны хэрэгсэл, аймгийн ЗДТГ-аас 38189.6 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл нийт 146789.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх, данс бүртгэлээс акталж хасагдаагүй, биет бус хөрөнгөтэй холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 65860.3 мянган төгрөг болж 65860.3 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд Ховд Дулааны станц ТӨХК-д төлөх дулааны 18285.3 мянган төгрөг, БТСГ-ын 97 тоот тушаалаар “Цахим фитнес” төслийн 13120.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаа зохион байгуулж чадаагүй татан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 18285.3 мянган төгрөгийн өр төлбөр 2020 онуудад түлш халаалтын зардалтай холбоотой үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3046804.3 мянган төгрөг болж 99700.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх үеийн үр дүн данс руу залруулах бичилт хийгдсэн, тайлант онд 81415.8 мянган төгрөгийн алдагдалтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Биеийн тамир, спортын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 75571.9 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй 146789.9 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан байна. Энэ нь холбогдох дээд шатны байгууллага, орон нутгийн удирдах байгууллагуудаас хөрөнгө шилжүүлэн өгснөөс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 117348.8 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил,

шимтгэлийн зардал 13751.5, тогтмол зардал 41183.6, хангамж бараа материалын зардал 567.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 531.2, орон нутгийн төсөвт 12388.3 мянган төгрөгөөр тус тус өссөн, норматив зардал 167.3, бусад урсгал шилжүүлэг 249.5, бараа үйлчилгээний бусад зардал 184865.8, дотоод томилолтын зардал 488.0 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 18285.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх онд үүссэн түлш халалтын зардлын өр төлбөрийг залруулан бичсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 622052.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 622052.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 531827.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 2020 оны 9 дүгээр сарын 11/02 тоот тогтоолоор 497595.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 7500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 497595.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 500.0 мянган төгрөг, нийт 498095.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 498095.1 мянган төгрөгийг зарцуулж 569 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн, үндсэн үйл ажиллагааны орлогыг батлагдсан төлөвлөгөөнөөс 7000.0 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 498095.1 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 5540.3, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11126.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, бараа үйлчилгээний зардлыг 9265.8, урсгал шилжүүлгийн зардлыг 400.0 тус тус хэтрүүлэн зарцуулсан нь 2019 онд байгууллагын үйл ажиллагааны бичиг хэрэг, урсгал засвар болон бусад бараа үйлчилгээний зардлыг төлөөгүйгээс шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 9157.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой спортын үйл ажиллагаа явагдаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн бүрдүүлж чадаагүйгээс шалтгаалсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,297.4
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	1,126.3
80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	734.2
	<b>ДҮН</b>	<b>9,157.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ОНХС-аас А/104 тоот захирамжаар “Токио 2020” пара олимпид оролцох тамирчны замын зардал 950.0, “хөл бөмбөгийн улсын аварга тэмцээн”-ний замын зардалд 2800.0, Булган аймагт зохион байгуулагдах “Өсвөр үеийн үндэсний бөх”-ын улсын аварга шалгаруулах тэмцээнд замын зардал 900.0, А/791 тоот захирамжаар “Оны шилдэг дасгалжуулагч, тамирчдын урамшуулал”-ын зардалд 13685.0, БТСГ-ын 36 тоот тушаалаар “Өртөөт марафон” тэмцээний үйл ажиллагааны зардалд 7380.0, газрын даргын 98 тоот тушаалаар “Цахим мэдээллийн сан” бүрдүүлэхэд 2000.0, БТСГ-ын 97 тоот тушаалаар “Цахим фитнес” төслийг хэрэгжүүлэх зардалд 13120.0 мянган төгрөг нийт 41335.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Токио 2020 пара олимп 950.0, Марафон гүйлтэд 7380.0, өсвөрийн үндэсний бөхийн үйл ажиллагаанд 900.0, оны шилдэг дасгалжуулагч, тамирчдын шагналд 13684.8, байгууллагын цахим вэб сайтад 2000.0, хөл бөмбөгийн УАШТэмцээнд 2800.0, байгууллагын үйл ажиллагаанд 500.0 нийт 28214.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13120.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 134 мэдээлэл, 13 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлага, 22723.7 мянган төгрөгийн 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг хянахад 2020 оны 1 дүгээр сард 8750.0 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад нэг удаа олгодог мөнгөн тэтгэмж, 5750.0 мянган төгрөгийн түлш халаалтын зардалд төлсөн ажил гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 38101.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 25 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	38,101.1	1		1	38,101.1	25%
Нийт дүн	2	38,101.1	1	-	1	38,101.1	25%

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 236815.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 217991.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 999.5 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож 17823.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн данс руу оны эцэст дээд шатны байгууллагаас тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой орсон орлогыг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн боловч авлага, өглөгийг 26240.0 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй,
2. Өмнөх онд түлш халаалтын зардалтай холбоотой 18285.3 мянган төгрөгийг байгууллагад өгөх өглөгөөр тусгаагүй тайлант онд төлж зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
3. Бараа материалаас 694.0 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийг худалдан авч зарлага болгосон,
4. Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг 76896.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
5. Тайлант оны үр дүнг 95875.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасанатай холбоотой нийт 217991.8 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж 217991.8 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 999.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 999.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй төсвийн захирагч нь хувийн үйл ажиллагаанд зарцуулсан, албан хаагчдад сар бүр олгох унаа хоолны хөнгөлөлтийг ажиллаагүй хоногт илүү олгосон, цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүй санхүүгийн тайланд дутуу тусгасан нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 17823.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн ЗДТГ-ын даргын аман шийдвэрээр байгууллагын гаднах талбай болон засмал зам дагуух газрын зүлэгжүүлэх, ойжуулах ажилд төсвөөс 2025.0 мянган төгрөгийн зардал гаргаж зарцуулсан нь анхаарал татахуйц асуудалтай байна.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд нийт 2487.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч дотоод хяналтгүй, жолоочийн тооцооны хуудсанд байгууллагын даргын хувийн машинд хийж зарцуулснаар тооцоо бодсон, 12 дугаар сард Ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа бүрэн явагдаагүй байхад 274 литр шатахуун зарцуулсан нь төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

##### 2. Улирлын мөнгөн урамшуулал олгохтой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Байгууллагын ажилчдын ажлын үр дүнг тооцож хамт олноор хэлэлцүүлэн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгоогүй, ур чадварын нэмэгдлийг зөвхөн нягтлан бодогч, архив ажилтан нарт олгож бусдад ажилчдад олгоогүй зөрчил дутагдал байна.

2.2. Эрсдэл: Ажлын үр дүн буурах, хариуцлага алдагдах

2.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3 дугаар хавсралтын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын цалингийн 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

##### 3. Зардлын данстай холбоотой асуудал

**3.1. Илрүүлэлт:** Байгууллагын даргын А/11 тоот тушаалаар гаднах талбайг зүлэгжүүлэх, ойжуулах ажилд шаардлагатай материал худалдан авахад зардал гаргасан боловч хэчнээн хэмжээний материал худалдан авсныг нотлох анхан шатны баримтгүй байна.

Мөн өмнөх 2019 оны бичиг хэрэг, урсгал завсар болон аж ахуйн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан боловч тухайн онд орлого авч зарцуулалтын тайлан гаргаагүй санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 12816.7 мянган төгрөгийг 2020 онд төлж зардлаар хүлээн зөвшөөрснийг аудитын явцад залруулаагүй болно.

**3.2. Эрсдэл:** Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах, төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, санхүүгийн тайлангийн бодит байдал алдагдах, үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

**3.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилт", 5.1.4- д "үнэн зөв байх" гэсэн заалтуудыг мөрдөн төсвийг үр ашигтай зарцуулах, санхүүгийн тайланг үнэн зөв гаргах талаар анхааран ажиллах

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

#### **4.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:** Байгууллагын данс бүртгэлд 3 санхүүгийн программ хангамж бүртгэлтэй байгаагаас 1 программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

**3.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

**3.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэх,

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

#### **5.Шилэн данстай холбоотой асуудал**

**5.1. Илрүүлэлт:** Шилэн дансны хуульд заасны дагуу сар бүрийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, 9 сард төлсөн халаалтын зардлын ажил гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ОНХС болон БТСГ-аас орсон орлого, зарлагын ажил гүйлгээ, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан, батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийн мэдээллийг байршуулаагүй байна.

**5.2. Эрсдэл:** Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх,

**5.3. Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.5.4-д "улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр" мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

**5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<b>Биеийн тамир, спортын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ХОА-2021/123/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Биеийн тамир, спортын газар</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Албан хаагчдад сар бүр олгох унаа хоолны хөнгөлөлтийг ажиллаагүй хоногт илүү олгосон, цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүй санхүүгийн тайланд дутуу тусгасан	512.8	Төлбөрийн акт	Газрын даргын үүргийг орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Ч.Түмэн дэмбэрэл, О.Пүрэвсүх
2	Шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй төсвийн захирагч нь ямар үйл ажиллагаанд зарцуулсан нь тодорхой бус	486.7	Төлбөрийн акт		
3	Өмнөх онд халаалтын болон бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулсан зардлыг тайлант онд төлж тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн, нэмэлт санхүүжилтийн данснаас орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн, фитнесийн тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийг өглөгөөр бүртгээгүй	44525.3	Залруулга хийх		
4	БҮТЭЗ-ийг худалдан авч шууд зарлага болгон зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн	694.0	Залруулга хийх		
5	Тайлант оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	76896.6	Залруулга хийх		
6	Тайлант оны хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн	95875.9	Залруулга хийх		
7	Байгууллагын даргын А/11 тоот тушаалаар байгууллагын гаднах талбайг зүлэгжүүлэх, ойжуулах ажилд шаардлагатай материал худалдан авахад зардал гаргасан боловч хэчнээн хэмжээний материал худалдан авсныг нотлох анхан шатны баримтгүй, 2019 оны бичиг хэрэг, урсгал завсар болон аж ахуйн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан боловч тухайн онд орлого авч эд хариуцагчийн тайлан гаргаагүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, 2020 онд төлж зардлаар хүлээн	14211.7	Зөвлөмж өгөх		

	зөвшөөрснийг аудитын явцад залруулаагүй болно.		
8	Тайлант онд нийт 3000.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч дотоод хяналтгүй, жолоочийн тооцооны хуудсанд байгууллагын даргын хувийн машинд хийж зарцуулснаар тооцоо бодсон, 12 дугаар сард Ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа бүрэн явагдаагүй байхад 274 литр шатахуун зарцуулсан нь төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулаагүй	2487.2	Зөвлөмж өгөх
9	2020 онд албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгоогүй цалингийн зардлаас татан төвлөрүүлсэн		Зөвлөмж өгөх
10	Байгууллагын данс бүртгэл 3 санхүүгийн программ хангамж бүртгэлтэй байгаагаас 1 программ хангамж ашиглагдаж байгаа ашиглахгүй байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй	495.0	Зөвлөмж өгөх
11	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлт, 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын ажил гүйлгээг мэдээлээгүй		Зөвлөмж өгөх
<b>ДҮН</b>		236815.2	

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР